



Нийгмийн
Даатгалын
Ерөнхий Газар



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ
ᠳᠠᠠᠲᠭᠠᠯᠢ
ᠭᠠᠷᠢᠨ ᠠᠪᠯᠠᠭ᠎ᠠ

НИЙГМИЙН ДААТГАЛ

ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2021 он

АГУУЛГА

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ	2
Нийгмийн даатгалын төрөл, хэлбэр	3
Албан журмын даатгуулагч гэж хэн бэ?	3
Сайн дурын даатгуулагч гэж хэн бэ?.....	4
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	9
Нэг.Тэтгэврийн даатгал	9
Өндөр насны тэтгэвэр	9
Тахир дутуугийн тэтгэвэр	15
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	17
Тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг	19
Хоёр. Тэтгэмжийн даатгал	21
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	22
Жирэмсний болон амаржсаны тэтгэмж	24
Оршуулгын тэтгэмж.....	25
Гурав. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал	27
ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох тахир дутуугийн тэтгэвэр	28
ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох тэжээгчээ алдсаны тэтгэвэр	29
ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох ХЧТА-ны тэтгэмж.....	30
Дөрөв. Ажилгүйдлийн даатгал	31
Ажилгүйдлийн тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичиг	32
Мэргэжлийн сургалтад хамрагдах	32
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛЭЛЦЭЭРҮҮД	33
- БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд байгуулсан “Нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”	33
- МУ-ын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хооронд байгуулсан “Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр”	34
- МУ-ын Засгийн газар, БНУУ-ын Засгийн газар хооронд байгуулсан “Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр”	35
- МУ-ын Засгийн газар, БНЧУ-ын Засгийн газар хооронд байгуулсан “Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр”	36
- МУ-ын Засгийн газар, БНПУ-ын Засгийн газар хооронд байгуулсан “Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр”	37
- МУ-ын Засгийн газар, БНТУ-ын Засгийн газар хооронд байгуулсан “Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр”	38
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ	39
Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт	39
Даатгуулагчдад зориулсан вэб	40
“Нийгмийн даатгал” гар утасны аппликейшн	42
ХАВСРАЛТУУД	45
Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн утасны жагсаалт	45
Нийгмийн даатгалын шимтгэл төлөх дансны дугаар.....	46

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ


НИЙГМИЙН ДААТГАЛ нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, түүнчлэн даатгуулагч нас барахад түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Та эрдэнэт хүний биеийг олж эхийн хэвлийд бүрэлдэж эхэлмэгцээ л нийгмийн даатгалын үр шимийг хүртэж эхэлдгээ мэдэх үү?

Ээж тань нийгмийн даатгалд даатгуулсан болохоор жирэмсэн, амаржсаны тэтгэмжээрээ нэмэлт амин дэм авч, өлгий живхийг тань зэхдэг. Энэ хорвоод ирэхэд тань эрүүл мэндийн даатгалаас төрөх эмнэлгийн төлбөрийг санхүүжүүлж эсэн мэнд угаж авдаг. Ингээд таныг 19 нас хүртэл төрөөс хариуцан эрүүл мэндийн даатгалыг тань төлж, хэрвээ өвдвөл эмчилж, сувилж, шаардлагатай эмийг хөнгөлөлттэй үнээр олгодог.

Амьдралд тохиолдож болох жам ёсны болон гэнэтийн эрсдэлийн улмаас тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох нь ч бий. Энэ болтол өөрөөс хамааралгүйгээр нийгмийн даатгалын үйлчилгээг хүртэж ирдэг бол насанд хүрсэн өдрөөсөө эхлэн учирч болох эрсдэлийг урьдчилан тооцоолж, нийгмийн даатгалаа өөрөө хариуцан төлж эхэлдэг.

» Хүний амьдралд ямар эрсдэлүүд тохиолдож болох вэ?



Монгол Улсын нийгмийн даатгалын тогтолцоо нь нийгмийн даатгалын санг төр, ажил олгогч, даатгуулагч хамтран бүрдүүлсний үндсэн дээр даатгуулагч иргэдэд тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал авах хөрөнгийн эх үүсвэрийг бий болгож, нийгмийн баталгааг нь хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТӨРӨЛ, ХЭЛБЭР

Нийгмийн даатгал нь 5 төрөлтэй бөгөөд төрөл тус бүр нь бие даасан сантай байдаг. Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл, сангийн чөлөөт үлдэгдлийг банканд хадгалуулсны хүүгийн орлого, улсын төсвөөс олгох хөрөнгө болон бусад орлогоос бүрдэнэ.



Зураг 1. Нийгмийн даатгалын төрөл

Нийгмийн даатгалд иргэд албан журмаар болон сайн дураар гэсэн 2 хэлбэрээр даатгуулж болдог.

»» Албан журмын даатгуулагч гэж хэн бэ?

Өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй дараах гэрээгээр ажиллаж байгаа Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн албан журмаар даатгуулна:

- **Хөдөлмөрийн гэрээ** (Хөдөлмөрийн тухай хуульд заасан)
- **Ажил гүйцэтгэх гэрээ** (Иргэний хуулийн 343 дугаар зүйлд заасан)
- **Хөлсөөр ажиллах гэрээ** (Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан)

Албан журмын даатгуулагчийн болон ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээ:

Нийгмийн даатгалын төрөл	Ажил олгогч	Албан журмын даатгуулагч
Тэтгэврийн даатгал	8.5%*	8.5%*
Тэтгэмжийн даатгал	1.0%	0.8%
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал	0.8%, 1.8%, 2.8%	-
Ажилгүйдлийн даатгал	0.2%	0.2%
Эрүүл мэндийн даатгал	2%	2%
Нийт	12.5%, 13.5%, 14.5%	11.5%*

*2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

» Сайн дурын даатгуулагч гэж хэн бэ?

Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ байгуулан, албан журмаар даатгуулснаас бусад хөдөлмөрийн насны бүх иргэн нийгмийн даатгалд сайн дурын хэлбэрээр хамрагдах боломжтой.




Хэрвээ Та сайн дураар даатгуулахаар шийдсэн бол нийгмийн даатгалын дараах 3 төрөлд даатгуулна. Үүнд:



ИРГЭН ТА

- Тэтгэврийн даатгал
- Тэтгэмжийн даатгал
- YOMШӨ-ний даатгал




*2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

»» Сайн дурын даатгалын гэрээг хэрхэн байгуулах вэ?

Нийгмийн даатгалд сайн дурын хэлбэрээр хамрагдахдаа Нийгмийн даатгалын байгууллага(байцаагч)-тай “Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай” гэрээ байгуулах бөгөөд гэрээндээ нийгмийн даатгалын шимтгэл тооцох сарын орлого, шимтгэл төлөх хугацаагаа тодорхой тусгаж өгдөг.

Сайн дурын даатгуулагч нь шимтгэл тооцох сарын орлогоо тодорхойлохдоо тухайн үед мөрдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, уг доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс ихгүй байхаар мэдүүлнэ.



Хөдөлмөр, нийгмийн зөвшилтийн гурван талт үндэсний хорооны 2018.08.19-ны өдрийн 05 тоот тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2020.01.01-ний өдрөөс 420 000 төгрөг байхаар тогтоосон.

Сайн дурын даатгуулагчдын хувьд өөрийн орлогын байдлаасаа хамааран шимтгэлээ сараар, улирлаар, бүр жилээр ч нэг дор төлөх боломжтой. Энэ нь улирлын чанартай орлого бүхий малчид, чөлөөт уран бүтээлчид, бичил уурхай эрхлэгчид, газар тариалан эрхлэгчдийн хувьд таатай боломж юм. Гагцхүү та шимтгэл төлөх хугацаагаа гэрээндээ тусгах ба гэрээний хугацаанд энэхүү тохиролцоо нь өөрчлөгдөхгүй гэдгийг анхаараарай.



Даатгуулагч сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, шилжилт хөдөлгөөнөө бүртгүүлэх, шимтгэлийн төлбөрөө төлөхийн тулд заавал нийгмийн даатгалын хэлтэс, банкны салбар дээр дугаарлах шаардлагагүй бөгөөд “Нийгмийн даатгал” гар утасны аппликейшн болон даатгуулагчид зориулсан вэбээр нэвтрэн дээрх үйлчилгээг орон зай, цаг хугацааны хамааралгүйгээр авах боломжтой.



Жишээ: Сайн дурын даатгуулагч өөрийн мэдүүлсэн орлогоосоо 13,5 хувиар тооцож шимтгэл төлнө.

Сайн дурын даатгуулагчийн өөрөө мэдүүлсэн сарын орлого (төгрөг)	Шимтгэл тооцох хувь хэмжээ	Сард төлбөл зохих шимтгэл (төгрөг)
420 000	13,5%	56 700
500 000		67 500
600 000		81 000
700 000		94 500
800 000		108 000
900 000		121 500
1 000 000		135 000
1 500 000		202 500
2 000 000		270 000
2 500 000		337 500
3 000 000		405 000
3 500 000		472 500
4 000 000		540 000
4 200 000		567 000

» Хүүхдээ асарч буй сайн дурын даатгуулагч эхийн шимтгэл төлөлт

3 хүртэлх насны хүүхдээ асарч буй сайн дурын даатгуулагч эх төлбөл зохих шимтгэлийнхээ 50 хувийг өөрөө төлсөн нөхцөлд үлдсэн 50 хувийг өмнө нь даатгуулж байсан эсэхээс хамаарч тэтгэмжийн даатгалын сангаас эсвэл улсын төсвөөс хариуцан төлнө. Шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон төлөх ба хүүхэд нь 3 нас хүрээгүй нийт эхчүүд хамаарна.



Жишээ:

420.000₮ * 12.5% = **52.500₮** (Нийт төлбөл зохих шимтгэл)

Үүнээс: 50% = **26.250₮** (Даатгуулагч эх өөрөө төлнө)

50% = **26.250₮** (Тэтгэмжийн даатгалын сангаас болон улсын төсвөөс хариуцан төлнө)



ДААТГУУЛАГЧ ТА ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР АВАХ ЭРХТЭЙ

- Нийтдээ 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн, 65 нас хүрсэн бол;
- Нийтдээ 25-аас доошгүй жил шимтгэл төлсөн эрэгтэй 60, эмэгтэй 55 нас хүрсэн бол (өөрөө хүсвэл);
- 4 ба түүнээс дээш хүүхдээ 6 нас хүртэл нь өсгөсөн эх 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн, 50 нас хүрсэн бол;
- Газрын дор болон хөдөлмөрийн хүнд, хортой, халуун нөхцөлд ажиллаж хуульд заасан нөхцөлийг хангасан бол;
- 10-20 хүртэл жил шимтгэл төлсөн 65 нас хүрсэн бол нийт шимтгэл төлсөн хугацаандаа ногдох тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгох эрхтэй.

НИЙГМИЙН ДААТГАЛД САЙН ДУРААР

ДААТГУУЛАГЧ ИРГЭН:

Ахмад настан Цогоо 1957 онд төрсөн бөгөөд 1996 он хүртэл авто баазад тээврийн жолоочоор 17 жил ажилласан ба 1997 оноос хувиараа бизнес эрхэлж таксид явжээ. Тэрээр 2002-2017 онд нийгмийн даатгалд сайн дураар хамрагдаж өндөр насны тэтгэврээ тогтоолгосон.

Цогоо гуай нийтдээ 32 жил ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд тэтгэвэр тогтоолгохдоо 2009-2016 оны хоорондох 7 жилийн цалин (сарын 680000 төгрөг)-гаа сонгон тэтгэврээ тогтоолгосноор сард **428.400** төгрөгийн тэтгэврийг авч байна.

ДААТГУУЛААГҮЙ ИРГЭН:

Ахмад настан Цогоо гуай нийгмийн даатгалд даатгуулаагүй бол түүнд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр олгохгүй байлаа.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ


1. ТЭТГЭВРИЙН ДААТГАЛ

ТЭТГЭВЭР гэдэг нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, тахир дутуу болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Тэтгэврийн даатгалын сангаас даатгуулагчид тогтоож олгох тэтгэвэр нь дор дурдсан 3 төрөлтэй байна. Үүнд:

- Өндөр насны тэтгэвэр
- Тахир дутуугийн тэтгэвэр
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр

ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР



Өндөр насны тэтгэвэр гэж даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь нийгмийн баталгааг нь хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагчийн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах гол үндэслэл нь түүний нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан хугацаа байдаг бөгөөд уг хугацаанаас хамааран тэтгэврийг бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоодог.

ӨНДӨР НАСНЫ БҮРЭН ТЭТГЭВЭР:

- Нийтдээ 21 жил+3сар* ба түүнээс дээш хугацаанд шимтгэл төлсөн 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болно.
- 2021 онд 21 жил шимтгэл төлсөн даатгуулагч өөрөө хүсвэл эрэгтэй 60 настайдаа, эмэгтэй 55 настайдаа тэтгэвэр тогтоолгож болно. Цаашид энэ хугацаа жил бүр 3 сараар нэмэгдэж 2037 оноос эхлэн 25 жил болно. (Хүснэгт 3-аас харах)

ӨНДӨР НАСНЫ ХУВЬ ТЭНЦҮҮЛСЭН ТЭТГЭВЭР:

- 10-20 хүртэл жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч Хүснэгт 2-т заасан төрсөн ондоо харгалзах насанд хүрсэн тохиолдолд өөрөө хүсвэл өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгон авч болно.
- Тухайлбал 1961 онд төрсөн эрэгтэй 61 насанд хүрээд, 1966 онд төрсөн эмэгтэй 56 насанд хүрээд өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож болно.

Хүснэгт 2

*Даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас:

Эрэгтэй даатгуулагчийн төрсөн он	Өндөр насны тэтгэвэр тогтоох нас	Эмэгтэй даатгуулагчийн төрсөн он	Өндөр насны тэтгэвэр тогтоох нас
1957 ба түүнээс өмнө	60 нас	1962 ба түүнээс өмнө	55 нас
1958	60 нас 3 сар	1963	55 нас 3 сар
1959	60 нас 6 сар	1964	55 нас 6 сар
1960	60 нас 9 сар	1965	55 нас 9 сар
1961	61 нас	1966	56 нас
1962	61 нас 3 сар	1967	56 нас 3 сар
....
....
1977 ба түүнээс хойш	65 нас	2002 ба түүнээс хойш	65 нас

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр өндөр насны тэтгэвэр тогтоох насыг нэмэгдүүлэхтэй холбоотой өөрчлөлт орж эрэгтэй даатгуулагчийн тэтгэврийн насыг 2027 он гэхэд, эмэгтэй даатгуулагчийн тэтгэврийн насыг 2037 он гэхэд 65 нас болгохоор баталсан. Үүний дагуу тэтгэврийн насыг 2018 оноос жил бүр 3 сараар нэмэгдүүлж байгаа бөгөөд энэ насыг тухайн онд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх хугацааг хангаагүй тохиолдолд баримтална.



Жишээ:

1962 онд төрсөн даатгуулагч (эрэгтэй) "А" нь нийтдээ 30 жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол 2022 онд 60 нас хүрээд өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно. Хэрвээ даатгуулагч "А"-ийн шимтгэл төлсөн нийт хугацаа нь 18 жил байсан бол тэрээр 61 нас 3 сар хүрээд өндөр насны тэтгэврээ хувь тэнцүүлэн тогтоолгоно.

Нөгөө талаас тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих доод хугацааны шатлалыг мөн 2018 оноос жил бүр 3 сараар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд хэрэв уг хугацааны болзлыг хангасан даатгуулагч өөрөө хүсвэл эрэгтэй 60 настайдаа, эмэгтэй 55 настайдаа өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно.

Хүснэгт 3

***Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа:**

Он	Тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа
2018	20 жил 3 сар
2019	20 жил 6 сар
2020	20 жил 9 сар
2021	21 жил
2022	21 жил 3 сар
2023	21 жил 6 сар
.....
.....



Жишээ:

1961 онд төрсөн эрэгтэй даатгуулагч 2021 онд 60 нас хүрээд өндөр насны тэтгэврээ тогтоолгох хүсэлт гаргавал 21 ба түүнээс дээш жил шимтгэл төлсөн байх шаардлагатай.

»» Тэтгэвэр бодох аргачлал:

Өндөр насны тэтгэврийг даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх аль дуртай дараалсан **7** жилийн буюу **84** сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас **45** хувиар бодож тогтооно.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жилээс илүү төлсөн жил тутамд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хөдөлмөрийн хөлсний хэмжээнээс **1.5** хувиар, сар тутамд **0.125** хувиар бодож нэмэгдэл олгоно.



Жишээ:

Даатгуулагч эрэгтэй тэтгэврийн даатгалын шимтгэлийг 30 жил 7 сар төлж байгаад 60 нас хүрээд өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор нийгмийн даатгалын байгууллагад хүсэлтээ гаргажээ. Түүний тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин нь 850.000 төгрөг гэвэл:

а) 20 жилд ногдох тэтгэвэр: $850.000\text{₮} * 45\% = \mathbf{382.500\text{₮}}$

б) Илүү ажилласан жилд ногдох тэтгэвэр:

$$30 \text{ жил} - 20 \text{ жил} = 10 \text{ жил} * 1.5\% = \mathbf{15\%}$$

$$850.000\text{₮} * 15\% = \mathbf{127.500\text{₮}}$$

в) Сард ногдох тэтгэвэр:

$$7 \text{ сар} * 0.125\% = \mathbf{0.875\%}$$

$$850,000\text{₮} * 0.875\% = \mathbf{7.437\text{₮}}$$

г) Нийт тэтгэвэр: $382.500\text{₮} + 127.500\text{₮} + 7.437\text{₮} = \mathbf{517.437\text{₮}}$

Тахир дутуугийн тэтгэвэр авч байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан жил тутамд нь 1 хувиар бодож нэмэгдүүлдэг.

Өндөр насны бүрэн тэтгэвэр тогтоох шимтгэл төлж ажилласан хугацааны болзлыг хангаагүй боловч 10-аас дээш жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчийн хувьд түүний шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэврийг хувь тэнцүүлэн бодож олгодог.

Тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоохдоо хуульд заасан шимтгэл төлөх хугацааг бүрэн хангасан нөхцөлд тухайн даатгуулагчид тогтоогдвол зохих сарын тэтгэврийг шимтгэл төлбөл зохих хугацааны нийт сарын тоонд хувааж, шимтгэл төлсөн нийт сарын тоогоор үржүүлж тооцно.



Жишээ:

Даатгуулагч "Б" тэтгэврийн даатгалын шимтгэлийг 18 жил 7 сар төлсөн бөгөөд хуульд заасан насны болзлыг хангаж өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор нийгмийн даатгалын байгууллагад хүсэлтээ гаргажээ. Түүний тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин нь 900.000 төгрөг гэвэл:

а) 20 жилд ногдох тэтгэвэр: $900.000\text{₮} * 45\% = \mathbf{405.000\text{₮}}$

б) Шимтгэл төлбөл зохих хугацааны нийт сарын тоо:

$$20 \text{ жил} * 12 \text{ сар} = \mathbf{240 \text{ сар}}$$

в) Нэг сард ногдох тэтгэвэр:

$$405.000\text{₮} : 240 \text{ сар} = \mathbf{1.687.5\text{₮}}$$

г) "Б"-ийн шимтгэл төлж ажилласан сарын тоо


$$(18 \text{ жил} * 12 \text{ сар}) + 7 \text{ сар} = \mathbf{223 \text{ сар}}$$

д) Сард олгох өндөр насны хувь тэнцүүлсэн тэтгэвэр:

$$1.687.5\text{₮} * 223 \text{ сар} = \mathbf{376.312\text{₮}}$$

» Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр тогтоох тэтгэвэр

Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл буюу газрын доорх, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд ажиллаж байсан даатгуулагчийн хувьд тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-иос доошгүй жил төлөөд хуульд заасан тухайн хөдөлмөрийн нөхцөлд ажиллавал зохих хугацааны болзлыг хангасан тохиолдолд ердийн нөхцөлд ажиллаж байсан даатгуулагчаас насны хувьд 5-10 жилийн өмнө өндөр насны тэтгэврээ тогтоолгох боломжтой байдаг.



» Олон хүүхэд төрүүлсэн эхийн тэтгэвэр

Төрүүлсэн болон 3 хүртэлх настайд нь үрчлэн авсан 4 ба түүнээс дээш хүүхдээ 6 нас хүртэл нь өсгөсөн эх нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлөөд өөрөө хүсвэл 50 настайдаа өндөр насны тэтгэвэр тогтоолгох боломжтой байдаг.

Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхчүүдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, тэтгэврийн үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилгоор төрүүлж, өсгөсөн хүүхэд бүрийн тоогоор нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан хугацааг 1 жил 6 сараар нэмэгдүүлэн тооцож тэтгэвэр тогтоодог бөгөөд энэхүү нэмэгдэл нь 2020 оноос хойш шинээр тэтгэвэр тогтоолгож байгаа бүх эхчүүдэд хамааралтай.



Жишээ:

Даатгуулагч "А" 55 настай, тэтгэврийн даатгалын шимтгэлийг 27 жил төлж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор нийгмийн даатгалын байгууллагад хүсэлтээ гаргажээ. Тэрээр 2 хүүхэд төрүүлж өсгөсөн бөгөөд тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин нь 1.000.000 төгрөг гэвэл:

- а) Нийт шимтгэл төлж ажилласан жил:
 $27 \text{ жил} + 3 \text{ жил} (2 \text{ хүүхэд} * 1 \text{ жил } 6 \text{ сар}) = 30 \text{ жил}$
- б) 20 жилд ногдох тэтгэвэр:
 $1.000.000\text{₮} * 45\% = 450.000\text{₮}$
- в) Илүү ажилласан жилд ногдох тэтгэвэр:
 $30 \text{ жил} - 20 \text{ жил} = 10 \text{ жил} * 1.5\% = 15\%$
 $1.000.000\text{₮} * 15\% = 150.000\text{₮}$
- г) Нийт тэтгэвэр: $450.000\text{₮} + 150.000\text{₮} = 600.000\text{₮}$

» Малчин даатгуулагчийн тэтгэвэр:



Малчин даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтоох насанд хүрэхээс 5 жилийн өмнө тэтгэвэр тогтоож байна.

» Тэтгэврийг нас харгалзахгүйгээр тогтоодог онцлог тохиолдол:

Сонгодог, мэргэжлийн урлагийн байгууллагад нийтдээ 20-иос доошгүй жил эдгээр ажил мэргэжлээр ажилласан, эсхүл нийтдээ 25 жил үүнээс эдгээр ажил мэргэжлээр 15-аас доошгүй жил ажиллаж шимтгэл төлсөн даатгуулагч өөрөө хүсвэл.

- Гоцлол дуучин
- Гоцлол бүжигчин
- Агаарын болон хэрэглэлийн гимнастик
- Акробат
- Тэнцвэр
- Уран нугаралт
- Хүнд жингийн үзүүлбэрийн жүжигчин
- Зэрлэг араатан, ан амьтан сургаж тоглуулагч
- Хөөмийчин
- Үлээвэр хөгжимчин

Төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанд 25-аас доошгүй жил ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч өөрөө хүсвэл.

- Шүүгчээр 25 ба түүнээс дээш жил ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн шүүгч өөрөө хүсвэл;
- 30 ба түүнээс дээш жил ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, 55 насанд хүрсэн шүүгч өөрөө хүсвэл.

ТАХИР ДУТУУГИЙН ТЭТГЭВЭР



Тахир дутуугийн тэтгэвэр гэж даатгуулагчийг тахир дутуу болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл нийгмийн баталгааг нь хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас доошгүй хувиар байнга буюу удаан хугацаагаар алдсан тохиолдолд түүний тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанаас хамааран тахир дутуугийн тэтгэврийг бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоодог.

ТЭЖЭЭГЧЭЭ АЛДСАНЫ ТЭТГЭВЭР



Тэжээгчээ алдсаны тэтгэвэр гэж даатгуулагчийг нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн нийгмийн баталгааг нь хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Нас барсан тэжээгчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанаас хамааран түүний асрамжид байсан гэр бүлийн гишүүдэд тэжээгчээ алдсаны тэтгэврийг бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоодог.

ТЭЖЭЭГЧЭЭ АЛДСАНЫ БҮРЭН ТЭТГЭВЭР:

- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 ба түүнээс дээш жил төлсөн бол
- Эсхүл нас барахын өмнөх 5 жилийн 3 жилд нь шимтгэл төлсөн бол

ТЭЖЭЭГЧЭЭ АЛДСАНЫ ХУВЬ ТЭНЦҮҮЛСЭН ТЭТГЭВЭР:

- Нийтдээ 5-аас доошгүй жил, үүнээс 1 жил нь тасралтгүй тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол

Тэжээгчийн гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд:

- Төрүүлсэн болон үрчлэн авсан 19 нас хүрээгүй хүүхэд;
- Эцгээ нас барснаас хойш 280 хоногийн дотор мэндэлсэн, төрсөн хүүхэд;
- Хууль ёсоор тэжээх өөр хүнгүй 19 нас хүрээгүй ач, зээ, төрсөн дүү;
- Тэжээгчийн асрамжид байсан төрөлхийн тахир дутуу болон 16 нас хүрээгүй байхдаа тахир дутуу болсон хүүхэд, ач, зээ, төрсөн ах, эгч, дүү;
- Эрэгтэй нь 60, эмэгтэй нь 55 нас хүрсэн буюу эсхүл тахир дутуу болсон эцэг, эх, эхнэр, нөхөр, хууль ёсоор тэжээх өөр хүнгүй өвөг эцэг, эмэг эх, төрсөн ах, эгч, дүү;
- Найман нас хүрээгүй хүүхэд, хууль ёсоор асрах хүнгүй төрсөн дүү, ач, зээг нь асарч ажил хийгээгүй байгаа эцэг, эх буюу нөхөр, эхнэрийн аль нэг (нас, хөдөлмөрийн чадварыг харгалзахгүйгээр)
- Дагавар хүүхэд нь тэжээгч байгаад нас барсан бол хойд эцэг, эх нь төрсөн эцэг, эхийн адил;

- Төрсөн эцэг, эхээс шүүхийн шийдвэрээр тэтгэлэг авдаггүй хүүхэд хойд эцэг буюу эхийгээ нас барахад төрсөн хүүхдийн адил.

»» Тэтгэвэр бодох аргачлал:

Тэжээгчээ алдсаны тэтгэврийг өндөр насны тэтгэвэр бодох аргачлалаар буюу сарын дундаж хөдөлмөрийн хөлс, орлогын 45 хувиар тогтоож, 20-иос илүү ажилласан жил тутамд 1.5 хувиар, сар тутамд 0.125 хувиар бодож нэмэгдэл тооцсон хэсгээс хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоог харгалзан дор дурдсан хувь хэмжээгээр бодно:

Хүснэгт 4

Гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоо	Тэтгэвэр бодох хувь
3 ба түүнээс дээш	100%
2	75%
1	50%

Жишээ:

Даатгуулагч "Д" 25 жил шимтгэл төлж байгаад ердийн өвчний улмаас нас барсан. Түүний ар гэрт насанд хүрээгүй 2 хүүхэд үлдсэн бөгөөд дундаж цалин нь 1.000.000 төгрөг гэвэл:

а) 20 жилд ногдох тэтгэвэр:

$$1.000.000\text{₮} * 45\% = \mathbf{450.000\text{₮}}$$

б) Илүү ажилласан жилд ногдох тэтгэвэр:

$$25 \text{ жил} - 20 \text{ жил} = 5 \text{ жил} * 1.5\% = \mathbf{7.5\%}$$

$$1.000.000\text{₮} * 7.5\% = \mathbf{75.000\text{₮}}$$

в) Өндөр насны тэтгэвэр бодох хувьд ногдох хэсэг:

$$450.000 + 75.000\text{₮} = \mathbf{525.000\text{₮}}$$

г) Сард олговол зохих тэжээгчээ алдсаны тэтгэвэр:

$$525.000\text{₮} * 75\% (2 \text{ хүүхэдтэй}) = \mathbf{393.750\text{₮}}$$



Тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг

<p>Өндөр насны тэтгэвэр:</p>	<ul style="list-style-type: none"> ❖ Өргөдөл ❖ Иргэний үнэмлэхийн хуулбар ❖ Нийгмийн даатгалын дэвтэр (2021 оноос өмнөх) ❖ Хөдөлмөрийн дэвтэр (1995 оноос өмнөх) ❖ Цалингийн тодорхойлолт ❖ Цэргийн батлах (эрэгтэй даатгуулагч) ❖ Шүүхийн шийдвэр ❖ Хүүхдийн гэрчилгээний хуулбар (эмэгтэй даатгуулагч)
<p>Тахир дутуугийн тэтгэвэр:</p>	<ul style="list-style-type: none"> ❖ Өргөдөл ❖ Иргэний үнэмлэхийн хуулбар ❖ Нийгмийн даатгалын дэвтэр (2021 оноос өмнөх) ❖ Хөдөлмөрийн дэвтэр (1995 оноос өмнөх) ❖ Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоос хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоосон акт
<p>Тэжээгчээ алдсаны тэтгэвэр:</p>	<ul style="list-style-type: none"> ❖ Өргөдөл ❖ Иргэний үнэмлэхийн хуулбар ❖ Нийгмийн даатгалын дэвтэр (2021 оноос өмнөх) ❖ Хөдөлмөрийн дэвтэр (1995 оноос өмнөх) ❖ Нас барсны гэрчилгээ ❖ Гэрлэлтийн баталгаа эсхүл шүүхийн шийдвэр ❖ Хүүхдийн төрсний гэрчилгээ ❖ Асран хамгаалагчаар тогтоосон Засаг даргын захирамж
<p>Малчин даатгуулагчийн тэтгэвэр:</p>	<ul style="list-style-type: none"> ❖ Өргөдөл ❖ Иргэний үнэмлэхийн хуулбар ❖ Нийгмийн даатгалын дэвтэр ❖ Хөдөлмөрийн дэвтэр ❖ Цалингийн тодорхойлолт ❖ Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүний хөдөлмөрийн дэвтэр ❖ Тухай үед оршин сууж байсан тухай баг, хорооны Засаг даргын тодорхойлолт ❖ Малчнаар томилсон, чөлөөлсөн тухай тушаал эсхүл хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах гэрээ ❖ Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн дагуу ажилласан жилээ нөхөн тооцуулсан баталгаажилтын хуудас ❖ Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн дагуу тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлсөн баталгаажилтын хуудас ❖ 1995 оноос хойш малчнаар ажилласныг нотлох “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллого”-ын бүртгэл, лавлагаа буюу “А” дансны лавлагаа



ДААТГУУЛАГЧ ТА ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ ТЭТГЭМЖ АВАХ ЭРХТЭЙ

*Даатгуулагчийн шимтгэл
төлж ажилласан
хугацааг харгалзан
сүүлийн 3 сарын дундаж
хөдөлмөрийн хөлснөөс
50-75 хувиар бодож
тэтгэмж олгоно.*

НИЙГМИЙН ДААТГАЛД САЙН ДУРААР

ДААТГУУЛАГЧ ИРГЭН:

Малчин Сумъяа 2000 оноос нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан бөгөөд 2020 онд өөрийн орлогыг **500.000** төгрөгөөр тодорхойлон даатгуулсан.

Тэрээр 2020 онд малаа хариулж яваад мотоциклын ослын улмаас хөдөлмөрийн чадвараа алдан эмнэлэгт ажлын **45** өдөр хэвтэн эмчлүүлж хөдөлмөрийн чадвар нь сэргэжээ.

Даатгуулагч Сумъяа нь хөдөлмөрийн чадвар түр алдсан хугацаанд ногдох **642.850** төгрөгийн тэтгэмжийг авч өөрт учирсан санхүүгийн эрсдэлийг бууруулж чадсан байна.

ДААТГУУЛААГҮЙ ИРГЭН:

Хэрэв малчин Сумъяа нийгмийн даатгалд хамрагдаагүй бол гэр бүл нь түүний хөдөлмөрийн чадвар алдсанаас тодорхой хэмжээнд санхүүгийн эрсдэлд орж болзошгүй байлаа.

2. ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛ

ТЭТГЭМЖ гэж хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Тэтгэмжийн даатгалын сангаас даатгуулагчид олгох тэтгэмж нь дор дурдсан 3 төрөлтэй байна. Үүнд:

- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны
- Жирэмсний болон амаржсаны
- Оршуулгын

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж



Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдахаас өмнө 3 ба түүнээс дээш сарын хугацаагаар төлсөн даатгуулагч хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж авах эрхтэй.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг даатгуулагчийн тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанаас хамааралтайгаар сүүлийн бүтэн ажилласан 3 сарын хөдөлмөрийн хөлсний дунджаас дор дурдсан хувь хэмжээгээр бодно.

Тэтгэмж бодох хувь

Шимтгэл төлсөн хугацаа (жил)	Тэтгэмж бодох хувь
5 хүртэл	50%
5-14	55%
15 ба дээш	75%

Тэтгэмж олгох хугацааны хязгаар:

Тэтгэмж олгох хугацааны нэг удаагийн дээд хязгаар	Ажлын 66 өдөр
Хуанлийн жилд удаа дараа өвдсөн тохиолдолд	Ажлын 132 өдрөөс хэтрэхгүй
Хорт хавдар эсхүл сүрьеэгээр өвдсөн тохиолдолд	Ажлын 132 өдөр



Жишээ:

Даатгуулагч 5 жил тэтгэмжийн даатгалын шимтгэл төлж байгаад ердийн өвчний улмаас хуанлийн 14 хоног эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, эмнэлгийн хуудас бичүүлсэн гэвэл:

ХЧТАлдахын өмнөх бүтэн ажилласан 3 сар	Тухайн сарын ажлын хоног	Цалин хөлс (төг)
10	21	820.000
11	23	950.000
12	20	790.000
Нийт	64	2.560.000

- а) Нэг өдөрт ногдох цалин:
 $2.560.000\text{₮} : 64 \text{ хоног} = \mathbf{40.000\text{₮}}$
- б) Тэтгэмж бодох хувь:
5 жил - **55%**
- в) Нэг өдөрт ногдох тэтгэмж:
 $40.000\text{₮} * 55\% = \mathbf{22.000\text{₮}}$
- г) Эмнэлгийн хуудас бичсэн
14 хоногийн доторх ажлын өдөр: **10**
- д) Олговол зохих тэтгэмж:
 $22.000\text{₮} * 10 \text{ өдөр} = \mathbf{220.000\text{₮}}$



ДААТГУУЛАГЧ ТА ЖИРЭМСНИЙ БОЛОН АМАРЖСАНЫ ТЭТГЭМЖ АВАХ ЭРХТЭЙ

Даатгуулагч Та шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 100 хувиар тооцож 4 сарын турш тэтгэмж авна.

НИЙГМИЙН ДААТГАЛД САЙН ДУРААР

ДААТГУУЛАГЧ ИРГЭН:

Лангуу түрээслэгч Наран нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах орлогоо 750.000 төгрөгөөр тодорхойлон тэтгэмжийн даатгалын санд 1 жил 2 сар шимтгэл төлж даатгуулсан.

Даатгуулагч Наран жирэмсний болон амаржсаны тэтгэмж **3.100.000** төгрөгийг 4 сарын хугацаанд авчээ.

ДААТГУУЛААГҮЙ ИРГЭН:

Хэрэв Наран нийгмийн даатгалд хамрагдаагүй бол жирэмсэн болон амаржсан хугацаандаа ямар нэгэн тэтгэмж авахгүй байсан.

Жирэмсний болон амаржсаны тэтгэмж



Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг жирэмсний чөлөө авахаас өмнө 12 сараас доошгүй хугацаанд төлсөн, үүнээс сүүлийн 6 сарын шимтгэлийг тасралтгүй төлсөн даатгуулагч эх жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй.

Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 100 хувиар бодож, 4 сарын хугацаанд ажлын өдрөөр тооцон олгоно.

Даатгуулагч эхэд жирэмсний 31-32 долоо хоногтойд хяналт тавьж буй эмнэлгийн байгууллагаас жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг тус бүр 60 хоногийн хугацаагаар олгоно.

Жишээ:

Даатгуулагч эх 6 жил тасралтгүй тэтгэмжийн даатгалын шимтгэл төлж ажилласан, түүний сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлсний дундаж 500.000 төгрөг, түүнд жирэмсний эмнэлгийн хуудсыг 2020 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс хуанлийн 60 хоногоор бичиж олгосон гэвэл:

а) Сарын дундаж ажлын өдөр: **21.2 өдөр**

б) Нэг өдөрт ногдох хөдөлмөрийн хөлс, орлого:

$$500.000\text{₮} : 21.2 \text{ өдөр} = \mathbf{23.585\text{₮}}$$

в) Тэтгэмж олгох хоног: **43 өдөр**

(эмнэлгийн хуудсанд бичигдсэн хугацаан дахь ажлын өдрөөр тооцно)

г) Олговол зохих тэтгэмж:

$$23.585\text{₮} * 43 \text{ өдөр} = \mathbf{1.014.155\text{₮}}$$

Албан журмын даатгуулагч эх хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаандаа хэдэн ч удаа төрсөн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг анхны нөхцөлөөр авах боломжтой байдаг.

Оршуулгын тэтгэмж



Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг нийтдээ 36 сараас доошгүй хугацаагаар төлсөн даатгуулагч нь ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барсан бол түүний оршуулгад зориулан оршуулгын тэтгэмж олгоно.

Харин үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан даатгуулагчийн хувьд шимтгэл төлсөн хугацааг харгалзахгүйгээр оршуулгын тэтгэмж олгодог.

Оршуулгын тэтгэмжийн хэмжээг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл баталж байна.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 16 дугаар тогтоолоор оршуулгын тэтгэмжийн хэмжээг **1.000.000** төгрөгөөр тогтоосон.

Тэтгэмж тогтооход бүрдүүлэх баримт бичиг:

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	Жирэмсэн амаржсаны тэтгэмж	Оршуулгын тэтгэмж
<ul style="list-style-type: none"> ➤ Нийгмийн даатгалын дэвтэр ➤ Хөдөлмөрийн дэвтэр ➤ Эмнэлгийн хуудас ➤ Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт 	<ul style="list-style-type: none"> ➤ Хөдөлмөрийн дэвтэр ➤ Нийгмийн даатгалын дэвтэр ➤ Эмнэлгийн хуудас ➤ Албан журмын даатгуулагч ажил олгогчоороо дамжуулалгүй шууд банкин дахь өөрийн дансаараа тэтгэмж авах бол өргөдөл 	<ul style="list-style-type: none"> ➤ Нийгмийн даатгалын дэвтэр ➤ Хөдөлмөрийн дэвтэр ➤ Нас барсны гэрчилгээ



ТАХИР ДУТУУГИЙН БОЛОН ТЭЖЭЭГЧЭЭ АЛДСАНЫ ТЭТГЭВЭР АВАХ ЭРХТЭЙ

- *Ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас доошгүй хувиар алдаж тахир дутуу болсон бол;*
- *Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас даатгуулагч нас барсан тохиолдод түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд*

НИЙГМИЙН ДААТГАЛД САЙН ДУРААР

ДААТГУУЛАГЧ ИРГЭН:

Бичил уурхай эрхлэгч Дэлгэр нийгмийн даатгалд сайн дураар даатгуулж 1 жил 2 сар шимтгэл төлсөн. Дундговь аймагт уурхайд ажиллаж байх явцдаа осолд орж хөдөлмөрийн чадвараа 50 хувиар алдсан бөгөөд түүний ослын актыг сумын Засаг даргын захирамжаар байгуулсан “Үйлдвэрлэлийн ослыг судлан тогтоох” комисс тогтоожээ.

Түүний сарын орлого 800.000 төгрөг ба түүнд тахир дутуугийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвар алдсан өдрөөс эхлэн сэргээгдэх хүртэл сар бүр олгоно.

Даатгуулагч Дэлгэр тахир дутуугийн тэтгэвэрт **400.000** (800.000*50%) төгрөгийг сар бүр авч байна. Түүнчлэн тэрээр протез, ортопедийн төлбөр, рашаан сувиллын тусламж, үйлчилгээний болон ирж, очих унааны зардлыг даатгалын сангаас авах, тэтгэврийн даатгалын шимтгэлээ төлүүлэх эрхтэй.

ДААТГУУЛААГҮЙ ИРГЭН:

Дэлгэр нийгмийн даатгалд даатгуулаагүй бол түүнд даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгохгүй байлаа.

3. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛ



- Үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөж эрүүл мэндээр хохирох, амь насаа алдахыг “ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ” гэнэ.
- Богино хугацаанд цацраг идэвхт буюу химийн бодисын нөлөөгөөр хордохыг “ХУРЦ ХОРДЛОГО” гэнэ. Хурц хордлогыг үйлдвэрлэлийн осолтой адилтгаж үзнэ.
- Үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалсан өвчнийг “МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧИН” гэнэ.

Даатгуулагч дараах тохиолдолд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртөж гэмтсэн, өвчилсөн, мэргэжлээс шалтгаалсан өвчтэй болсон, эсхүл амь насаа алдсан бол үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгоно:

- Ажлын байрандаа болон бусад газарт ажил үүргээ гүйцэтгэх явцад
- Ажил эхлэхийн өмнө ажилд бэлтгэх буюу дууссаны дараа
- Ажлын байр, багаж хэрэгслээ эмхэлж цэгцлэх үед
- Ажилдаа ирэх, буцах замд осолд өртөх

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөнийг судлан бүртгэх:

Албан журмын даатгуулагч



Байгууллагын дэргэдэх үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс



48 цагийн дотор судлан бүртгэж, акт үйлдэн ажлын 3 өдөрт багтаан хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчид хүргүүлнэ.



Оршин суугаа орон нутгийн засаг захиргааны дэргэдэх үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс


Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр:

Тэтгэвэр	<ul style="list-style-type: none"> ➤ Тахир дутуугийн тэтгэвэр ➤ Тэжээгчээ алдсаны тэтгэвэр
Тэтгэмж	<ul style="list-style-type: none"> ➤ Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээх төлбөр	<ul style="list-style-type: none"> ➤ Хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед) хийлгэх зардлын тодорхой хувийг нөхөн олгох ➤ Зайлшгүй шаардлагаар гадаадад хийлгэсэн эмчилгээний зардлыг жишиг үнээр тооцон төлөх
Тэтгэврийн даатгалын шимтгэл	<ul style="list-style-type: none"> ➤ ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг төлөх
Рашаан сувиллын тусламж, үйлчилгээний зардал	<ul style="list-style-type: none"> ➤ Рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчний сувилалд сувилуулах зардал ➤ Рашаан сувилалд ирж, очих унааны зардал
Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	<ul style="list-style-type: none"> ➤ ҮОМШӨ-нөөс урьдчилан сэргийлэх сургалт ➤ ҮОМШӨ-нөөс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон сурталчилгаа

ҮОМШӨ-НИЙ ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТАХИР ДУТУУГИЙН ТЭТГЭВЭР



Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа удаан хугацаагаар буюу байнга алдаж тахир дутуу болсон бол шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзахгүйгээр тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгоно.




Жишээ:
 Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг 2 жил төлж байгаад мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 50%-иар алдсан, түүний дундаж цалин нь 900.000 төгрөг гэвэл:
 - Сард олговол зохих тэтгэвэр:
 $900.000\text{₮} * 50\% \text{ (ХЧАЛдалтын хувь)} = 450.000\text{₮}$

ҮОМШӨ-НИЙ ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭЖЭЭГЧЭЭ АЛДСАНЫ ТЭТГЭВЭР



Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас даатгуулагч нас барсан тохиолдолд түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгоно.

Тэжээгчийн сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос:





Жишээ:

Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг 1 жил төлж байгаад үйлдвэрлэлийн ослын улмаас нас барсан.Түүний ар гэрт хөдөлмөрийн чадваргүй 2 хүүхэд үлдсэн бөгөөд, сард 800.000 төгрөгийн цалинтай байсан гэвэл:

- Сард олговол зохих тэтгэвэр:

$800.000\text{₮} * 75\% (2 \text{ хүүхдэд ногдох хувь}) = 600.000\text{₮}$

ҮОМШӨ-НИЙ ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ ТЭТГЭМЖ



Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй. Ингэхдээ шимтгэл төлж ажилласан хугацааг үл харгалзан даатгуулагчийн сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 100 хувиар тооцож, ажлын өдрөөр бодож олгоно.

“

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг:

1. Иргэний үнэмлэх
2. Нийгмийн даатгалын дэвтэр (2021 оноос өмнөх)
3. Хөдөлмөрийн дэвтэр (1995 оноос өмнөх)
4. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоосон Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын акт
5. Үйлдвэрлэлийн ослын акт

”

4. АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛ



АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ нь даатгуулагчид учирсан эрсдэлийг бууруулах, хуваалцах, ажилгүй болсон даатгуулагчийг дараагийн ажилд орж орлоготой болох хүртэлх хуулиар тогтоосон хугацаанд нийгмийн даатгалын сангаас амьдралын баталгааны эх үүсвэр болгон олгож буй мөнгөн хөрөнгө юм.

Ажилгүйдлийн даатгалын сангаас даатгуулагчид дор дурдсан тэтгэмж, зардлыг олгоно. Үүнд:

- Ажилгүйдлийн тэтгэмж
- Мэргэжил олгох, давтан сургалтад хамруулахтай холбогдсон зардал

»» Ажилгүйдлийн тэтгэмж

Даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажлаас чөлөөлсөн тухай шийдвэр гарахаас өмнө **24** сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн **9** сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүснэ.

Урьд нь ажилгүйдлийн тэтгэмж авсан даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг 12 сараас доошгүй хугацаагаар төлсөн нөхцөлд тэтгэмж авах эрх нь дахин үүснэ.

Ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлсөн сүүлийн **3** сарын хөдөлмөрийн хөлс, орлогын дунджаас дараах хувь, хэмжээгээр тооцож, ажлын **76** өдрийн хугацаанд олгоно.

Хүснэгт 5

Шимтгэл төлж ажилласан хугацаа (жил)	Тэтгэмж бодох хувь
5 хүртэл	45%
5-10 хүртэл	50%
10-15 хүртэл	60%
15 ба түүнээс дээш	70%

Ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг 1995.01.01-ний өдрөөс хойш тооцно.

»» Ажилгүйдлийн тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичиг:

Даатгуулагч ажлаас чөлөөлөгдөн ажил олгогчтой тооцоо хийж дууссанаас хойш 14 хоногийн дотор оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ харьяалах нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-д бүртгүүлж, дараах баримт бичгийг бүрдүүлж өгөх үүрэгтэй. Үүнд:

- Өргөдөл
- Ажлаас чөлөөлсөн тухай шийдвэр
- Хөдөлмөрийн байгууллагад бүртгүүлсэн тухай тодорхойлолт



Жишээ:

Даатгуулагч 16 жил ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлж байгаад 2021 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс ажлаас чөлөөлөгдсөн гэвэл:

Шимтгэл төлсөн сүүлийн 3 сар	Цалин хөлс (төг)
10	1.500.000
11	1.820.000
12	1.810.000

- а) Сарын дундаж цалин: **1.710.000₮**
 $(1.500.000₮ + 1.820.000₮ + 1.810.000₮) : 3 \text{ сар}$
- б) Нэг сард ногдох тэтгэмж: **1.197.000₮**
 $1.710.000 \times 70\% \text{ (16 жилд ногдох хувь)}$
- в) Ажлын нэг өдөрт ногдох тэтгэмж: **56.462₮**
 $1.197.000₮ : 21.2 \text{ хоног (сарын дундаж хоног)}$
- г) Олговол зохих тэтгэмж:
 $56.462₮ * 76 \text{ хоног} = \mathbf{4.291.112₮}$


Мэргэжлийн сургалтад хамрагдах:

Ажилгүйдлийн тэтгэмж авах болзол хангасан даатгуулагч ажилгүй болсноос хойш 6 сарын дотор мэргэжил олгох болон давтан сургалтад хамрагдвал сургалтын зардлыг нь ажилгүйдлийн даатгалын сангаас төлнө.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ОЛОН УЛСЫН ХЭЛЭЛЦЭЭРҮҮД



***БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд байгуулсан
"Нийгэм хангамжийн салбарт хамтран
ажиллах тухай хэлэлцээр"***



1982.04.06-ны өдөр "Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын хооронд нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр"-ийг баталсан.

Хэлэлцээрийн гол агуулга:

Даатгуулагч Монгол Улс болон Оросын Холбооны Улсад шимтгэл төлж ажилласан хугацаагаа нэгтгэн тооцуулж, хэлэлцэн тохирогч аль нэг талын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр тогтоолгох харилцааг зохицуулсан.

Жишээ:

Монгол Улсын Иргэн "Г" нь 15 жил нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд Оросын Холбооны Улсад 20 жил ажиллаж амьдрахдаа Оросын Холбооны Улсын тэтгэврийн даатгалд мөн хамрагдсан гэвэл:

Иргэн "Г"-ийн Оросын Холбооны Улсад болон Монгол Улсад шимтгэл төлсөн жилийг нэгтгэн нийт 35 жил (15 жил+20 жил) ажилласнаар тооцно. Тэрээр Монгол Улсад тэтгэвэр тогтоолгох бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу, Оросын Холбооны Улсад тэтгэвэр тогтоолгох бол Оросын Холбооны Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу өндөр насны тэтгэврээ тогтоолгоно.



**Монгол Улсын Засгийн газар БНСУ-ын
Засгийн газар хооронд байгуулсан “Нийгмийн
хамгааллын салбарт хамтран ажиллах
хэлэлцээр”**



Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийг 2006 оны 05 дугаар сарын 08-ны өдөр байгуулж хоёр Улсын Их Хурлаар соёрхон баталснаар 2007 оноос хэрэгжиж эхэлсэн.

Хэлэлцээрийн гол агуулга:

Хоёр улсын иргэдийг тэтгэврийн даатгалд давхар даатгуулахгүйгээр өөрийн улсын тэтгэврийн даатгалд даатгуулах, хэрэв давхар даатгуулсан тохиолдолд Солонгосын үндэсний тэтгэврийн албанд төлсөн шимтгэлийг нь буцаан олгох явдал юм. Энэхүү хэлэлцээрээр Бүгд Найрамдах Солонгос Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа Монгол Улсын иргэд өөрийн орны тэтгэврийн даатгалд хамрагдаж, ирээдүйн амьдралын нийгмийн баталгаагаа хангах, тэтгэврийн даатгалын шимтгэлийг Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний тэтгэврийн даатгалд давхар төлөхгүй, Бүгд Найрамдах Солонгос Улсын хуулийн дагуу заавал хамрагдах тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх боломж бүрдсэн.

Жишээ:

Иргэн “А” нь нийтдээ 15 жил нийгмийн даатгалын шимтгэл төлж ажиллаж байгаад Бүгд Найрамдах Солонгос Улсад 5 жил хөдөлмөрийн гэрээгээр ажилласан. Тэрээр уг хугацаанд сар бүр 40.000 воныг Монгол улсын тэтгэврийн даатгалын санд төлсөн гэвэл:

“А” нь хэлэлцээрийн дагуу Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний тэтгэврийн даатгалд төлөх шимтгэлээс чөлөөлөгдөн сар бүр өөрийн орны тэтгэврийн даатгалд хамрагдсан тул тэтгэврийн насанд хүрээд нийтдээ 20 жил (15 жил + 5 жил) шимтгэл төлж ажилласнаар өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхтэй болно.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2014 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 20 дугаар тогтоолоор Бүгд Найрамдах Солонгос Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа Монгол улсын иргэдийн сард төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээг 40.000 воноос багагүй байхаар тогтоосон.



**Монгол Улсын Засгийн газар БНУУ-ын
Засгийн газар хооронд байгуулсан "Нийгмийн
хамгааллын салбарт хамтран ажиллах
хэлэлцээр"**



Монгол Улс болон Бүгд Найрамдах Унгар Улсын хоорондын Нийгмийн хамгааллын хэлэлцээрийг 2011 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Будапешт хотноо үйлдэж улмаар хоёр тал соёрхон баталснаар 2012 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн.

Хэлэлцээрийн гол агуулга:

Даатгуулагч Монгол Улс болон Бүгд Найрамдах Унгар Улсад шимтгэл төлж ажилласан хугацаагаа нэгтгэн тооцуулж хэлэлцэн тохирогч аль нэг талын хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгох харилцааг зохицуулсан. Хэрвээ даатгуулагч Монгол Улсад тэтгэвэр тогтоолгох бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу, Бүгд Найрамдах Унгар Улсад тэтгэвэр тогтоолгох бол Бүгд Найрамдах Унгар Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр тогтоолгоно.

Жишээ:

Монгол Улсын иргэн "Д" 60 настай, тэтгэврийн даатгалын санд 18 жил шимтгэл төлсөн, Бүгд Найрамдах Унгар Улсад 15 жил ажиллахдаа Бүгд Найрамдах Унгар Улсын тэтгэврийн даатгалд хамрагдаж шимтгэл төлсөн, тэтгэвэр тогтоох цалингийн дундаж нь 950.000₮ гэвэл түүнд олгох тэтгэврийг тооцож үзье.

- а) Нэгтгэн тооцсон хугацаа: 33 жил
(Монгол улсад 18 жил, Бүгд Найрамдах Унгар Улсад 15 жил)
- б) Тэтгэвэр бодох хувь - 64.5% (20 жил * 45% + 13 жил * 1.5%)
- в) 33 жилд ногдох тэтгэвэр: $950.000 * 64.5\% = 612.750₮$
- г) Монгол улсад шимтгэл төлсөн 18 жилийн эзлэх хувь: 54.55%
(18 жил : 33 жил * 100)
- д) 18 жилд ногдох тэтгэвэр: $334.255₮$ ($612.750₮ * 54.55\%$)
"Д"-д Монгол улсын тэтгэврийн даатгалын сангаас сар бүр **334.255₮**-ийн тэтгэвэр олгоно.

Бүгд Найрамдах Унгар Улсын хуулиар өндөр насны тэтгэврийн нас 62, шимтгэл төлбөл зохих хугацааны доод хязгаар 20 жил байдаг тул "Д" нь 62 нас хүрээд Бүгд Найрамдах Унгар Улсын талд өргөдлөө гарган Унгар улсад ажиллаж шимтгэл төлсөн цалин хөлснөөсөө 33 жилээр тэтгэвэр бодуулж, үүнээс тус улсад шимтгэл төлсөн 15 жилд ногдох тэтгэврийг Бүгд Найрамдах Унгар Улсын тэтгэврийн сангаас сар бүр авна.



**Монгол Улсын Засгийн газар
Бүгд Найрамдах Чех Улсын Засгийн газар
хооронд байгуулсан “Нийгмийн хамгааллын
салбарт хамтран ажиллах хэлэлцээр”**



Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрт хоёр тал 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Прага хотноо гарын үсэг зурсан.

Хэлэлцээрийн гол агуулга:

Даатгуулагч Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улсад шимтгэл төлж ажилласан хугацаагаа нэгтгэн тооцуулж аль нэг талын хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгох бол энэ асуудлыг хариуцсан хоёр улсын байгууллагад өргөдөл гарган хугацаагаа нэгтгэн тооцуулж тэтгэвэр тогтоолгох боломжтой. Хэрвээ даатгуулагч Монгол Улсад тэтгэвэр тогтоолгох бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу, Бүгд Найрамдах Чех Улсад тэтгэвэр тогтоолгох бол Бүгд Найрамдах Чех Улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөнө.

Жишээ:

Монгол Улсын Иргэн “Б” нь 60 настай, Монгол Улсын нийгмийн даатгалд 14 жил шимтгэл төлсөн, Бүгд Найрамдах Чех Улсад 21 жил ажиллаж, амьдрахдаа Бүгд Найрамдах Чех Улсын тэтгэврийн даатгалд мөн хамрагдсан гэвэл:

Иргэн “Б” нь Бүгд Найрамдах Чех Улс болон Монгол Улсад шимтгэл төлсөн жилээ нэгтгэн нийт 35 жил болгон тооцуулж, хоёр орноос тэтгэвэр тогтоолгон авах эрх үүснэ. Үүнд:

Иргэн “Б”-ийн шимтгэл төлж ажилласан хугацаа болон нас нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан болзлыг хангаж байгаа тул Монгол Улсын тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлтээ эхлээд гаргана. Түүний нийт шимтгэл төлсөн 35 жилд ногдох тэтгэврийг Монгол улсад ажиллаж шимтгэл төлсөн цалин хөлснөөс нь бодох бөгөөд үүнээс 14 жилд нь ногдох хэсгийг Монгол улсын тэтгэврийн даатгалын сангаас сар бүр олгоно.

Бүгд Найрамдах Чех Улсын хуулиар өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх нас эмэгтэй 57, эрэгтэй 60 нас, шимтгэл төлбөл зохих хугацааны доод хязгаар 35 жил бөгөөд иргэн “Б” уг шаардлагыг хангаж байгаа тул мөн тэтгэврийн эрх үүснэ. Иймээс иргэн “Б” нь Бүгд Найрамдах Чех Улсын талд өргөдөл гаргаснаар Чех Улсад ажиллаж шимтгэл төлсөн цалин хөлснөөсөө нийт шимтгэл төлсөн 35 жилд ногдох тэтгэврийг бодуулж, үүнийхээ 21 жилд ногдох тэтгэврийг Чех Улсын тэтгэврийн сангаас сар бүр авна.



**Монгол Улсын Засгийн газар
Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар
хооронд байгуулсан "Нийгмийн хамгааллын
салбарт хамтран ажиллах хэлэлцээр"**



Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийг 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хурал баталснаар 2019 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

Хэлэлцээрийн гол агуулга:

Хоёр улсад тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож, тэтгэвэр болон оршуулгын тэтгэмж тогтоох, олгох, тэтгэврийг харилцан шилжүүлэх, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, жирэмсний, амаржсаны, ажилгүйдлийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэмжүүдийг тогтоолгох боломжтой. Хэрвээ даатгуулагч Монгол Улсад тэтгэвэр тогтоолгох бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу, Бүгд Найрамдах Польш Улсад тэтгэвэр тогтоолгох бол Бүгд Найрамдах Польш Улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөнө.

Жишээ:

Монгол Улсын Иргэн "Г" 60 настай, Монгол Улсын нийгмийн даатгалд 17 жил шимтгэл төлсөн, Бүгд Найрамдах Польш Улсад 10 жил ажиллаж, амьдрахдаа Бүгд Найрамдах Польш Улсын тэтгэврийн даатгалд мөн хамрагдсан гэвэл:

Иргэн "Г" Монгол Улсын хуулийн дагуу тэтгэврийн насанд хүрсэн тул тэтгэврээ тогтоолгож болно. "Д"-ийн 27 жил шимтгэл төлсөн хугацаанд авах тэтгэврийг Монгол Улсад авч байсан цалин хөлснөөс нь бодож, түүнээсээ 17 жилд ногдох хэсгийг Монголын Улсын тэтгэврийн даатгалын сангаас сар бүр олгоно.

Бүгд Найрамдах Польш Улсын хуулиар өндөр насны тэтгэврийн нас нь эмэгтэй 60 нас, эрэгтэй 65 нас, тэтгэвэр тогтоох ажилласан хугацааны доод хязгаар нь эмэгтэй 20 жил, эрэгтэй 25 жил тул иргэн "Г" тус улсын тэтгэвэр тогтоох насны болзлыг хангасан тохиолдолд Бүгд Найрамдах Польш Улсын талд өргөдөл гаргаснаар Польш Улсад шимтгэл төлсөн 10 жилд ногдох тэтгэврийг Польш Улсын тэтгэврийн сангаас авна.



**Монгол Улсын Засгийн газар
Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар
хооронд байгуулсан “Нийгмийн хамгааллын
салбарт хамтран ажиллах хэлэлцээр”**



Хэлэлцээрт 2018 оны 03 дугаар сарын 07-ны өдөр гарын үсэг зурсан ба Улсын Их Хурлаас 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр соёрхон баталсан.

Хэлэлцээрийн гол агуулга:

Монгол Улс болон Бүгд Найрамдах Турк Улсад шимтгэл төлсөн, төлж байгаа бүх иргэн хамаарах ба хоёр улсад тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож тэтгэвэр болон оршуулгын тэтгэмж тогтоох, олгох, тэтгэврийг харилцан шилжүүлэх, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр олгох явдал юм. Хэрвээ даатгуулагч Монгол Улсад тэтгэвэр тогтоолгох бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу, Бүгд Найрамдах Турк Улсад тэтгэвэр тогтоолгох бол Бүгд Найрамдах Турк Улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөнө.

Жишээ:

Монгол Улсын Иргэн “С” нь 14 жил нийгмийн даатгалын шимтгэл төлсөн, тэрээр Бүгд Найрамдах Турк Улсад 21 жил ажиллаж, амьдрахдаа Бүгд Найрамдах Турк Улсын тэтгэврийн даатгалд мөн хамрагдсан гэвэл:

Иргэн “С” нь Бүгд Найрамдах Турк Улс болон Монгол Улсад шимтгэл төлсөн жилээ нэгтгэн нийт 35 жил болгон тооцуулж, хоёр орноос тэтгэвэр тогтоолгон авах эрх үүснэ.

Иргэн “С” нь тэтгэврийн нас болон шимтгэл төлсөн хугацааны аль алины хувьд Монгол Улсын хуульд заасан болзлыг хангаж байгаа тул өргөдлөө гаргаж Монгол Улсад өндөр насны тэтгэврээ эхлээд тогтоолгоно. “А”-ийн 35 жил шимтгэл төлсөн хугацаанд авах тэтгэврийг Монгол Улсад авч байсан цалин хөлснөөс нь бодож, түүнээсээ 14 жилд ногдох хэсгийг Монгол Улсын тэтгэврийн даатгалын сангаас сар бүр олгоно.

Бүгд Найрамдах Турк Улсын хуулиар өндөр насны тэтгэврийн нас эмэгтэй 58, эрэгтэй 60, шимтгэл төлсөн байвал зохих хугацааны доод хязгаар 20 жил байдаг бөгөөд иргэн “С” уг болзлыг хангаж байгаа тохиолдолд Турк Улсын талаас тус улсад шимтгэл төлсөн жилд ногдох хугацааны тэтгэвэр тогтоолгох боломжтой.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт нь даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаа, шимтгэл тооцсон цалин, орлогын мэдээллийг агуулсан, тусгай QR кодоор баталгаажсан баримт юм.

Даатгуулагч дараах сувгуудаас тодорхойлолтоо харах, PDF файлаар татаж авах, мэйлээр илгээх, хэвлэн авч ашиглах боломжтой.

ДААТГУУЛАГЧИЙН ВЕБ

*www.daatguulagch.
ndaatgal.mn*



E-MONGOLIA

www.e-mongolia.mn



ТҮЦ МАШИНААС АВАХ

*www.tushmashin.
gov.mn*




ГАР УТАСНЫ АПЛИКЕЙШН

 Google Play  App Store

Нийгмийн даатгал



Даатгуулагчид зориулсан веб




www.daatguulagch.ndaatgal.mn

Та доорх 3 төрлөөр бүртгүүлсэн аль ч эрхээрээ нэвтэрч орох боломжтой:

- Даатгуулагчид зориулсан веб сайтад бүртгүүлсэн эрхээрээ
- Нийгмийн даатгалын гар утасны аппликейшнд бүртгүүлсэн эрхээрээ
- ДАН системээр (Тоон гарын үсгээр, нэг удаагийн нууц үгээр)

Даатгуулагч Та өөрийн:




- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт
- Тэтгэвэр тогтоолт, олголтын талаар
- Тэтгэмж олголтын талаар
- Нэрийн дансны мэдээлэл
- Сайн дурын даатгалын мэдээлэл, гэрээ байгуулах, төлбөрөө төлөх
- Нийгмийн даатгалын цахим дэвтрээ харах боломжтой.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөө харах, хэвлэж авах



Хэлтсийн нэр	Ажил олгогчийн код	Ажил олгогчийн нэр	Он	Сар	Даатгуулагч Цалин	Төлөх шимтгэл	Ажил олгогч санхүүгийн төлөх өсөх
Хан-Уул дүүрэг	00999999	нийгмийн даатгалын сайн дурын даатгал	2018	1	600.000.00	78.000.00	Төлсөн
Хан-Уул дүүрэг	00999999	нийгмийн даатгалын сайн дурын даатгал	2018	2	600.000.00	78.000.00	Төлсөн
Хан-Уул дүүрэг	00999999	нийгмийн даатгалын сайн дурын даатгал	2018	3	600.000.00	78.000.00	Төлсөн
Хан-Уул дүүрэг	00999999	нийгмийн даатгалын сайн дурын даатгал	2018	4	600.000.00	78.000.00	Төлсөн
Хан-Уул дүүрэг	00999999	нийгмийн даатгалын сайн дурын даатгал	2018	5	600.000.00	78.000.00	Төлсөн
Хан-Уул дүүрэг	00999999	нийгмийн даатгалын сайн дурын даатгал	2018	6	600.000.00	78.000.00	Төлсөн
Хан-Уул дүүрэг	00999999	нийгмийн даатгалын сайн дурын даатгал	2018	7	600.000.00	78.000.00	Төлсөн
Хан-Уул дүүрэг	00999999	нийгмийн даатгалын сайн дурын даатгал	2018	8	600.000.00	78.000.00	Төлсөн
Хан-Уул дүүрэг	00999999	нийгмийн даатгалын сайн дурын даатгал	2018	9	600.000.00	78.000.00	Төлсөн
Хан-Уул дүүрэг	00999999	нийгмийн даатгалын сайн дурын даатгал	2018	10	600.000.00	78.000.00	Төлсөн
Хан-Уул дүүрэг	00999999	нийгмийн даатгалын сайн дурын даатгал	2018	11	600.000.00	78.000.00	Төлсөн
Хан-Уул дүүрэг	00999999	нийгмийн даатгалын сайн дурын даатгал	2018	12	600.000.00	78.000.00	Төлсөн
Хан-Уул дүүрэг	00999999	нийгмийн даатгалын сайн дурын даатгал	2020	4	420.000.00	56.700.00	Төлсөн
Хан-Уул дүүрэг	00999999	нийгмийн даатгалын сайн дурын даатгал	2020	5	420.000.00	56.700.00	Төлсөн
Хан-Уул дүүрэг	00999999	нийгмийн даатгалын сайн дурын даатгал	2020	6	420.000.00	56.700.00	Төлсөн
Хан-Уул дүүрэг	00999999	нийгмийн даатгалын сайн дурын даатгал	2020	7	420.000.00	56.700.00	Төлсөн
Хан-Уул дүүрэг	00999999	нийгмийн даатгалын сайн дурын даатгал	2020	8	420.000.00	56.700.00	Төлсөн
Хан-Уул дүүрэг	00999999	нийгмийн даатгалын сайн дурын даатгал	2020	9	420.000.00	56.700.00	Төлсөн
Хан-Уул дүүрэг	00999999	нийгмийн даатгалын сайн дурын даатгал	2020	10	420.000.00	56.700.00	Төлсөн
Хан-Уул дүүрэг	00999999	нийгмийн даатгалын сайн дурын даатгал	2020	11	420.000.00	56.700.00	Төлсөн
Хан-Уул дүүрэг	00999999	нийгмийн даатгалын сайн дурын даатгал	2020	12	420.000.00	56.700.00	Төлсөн

Сайн дурын даатгалын гэрээ байгуулах:




➤ Даатгуулагч гэрээний мэдээллийг тодорхойлж бүртгэнэ.

- Гэрээгээ зөвшөөрч хүсэлт илгээнэ
- Байцаагчид зориулсан вэб системүү илгээгдэнэ



Шимтгэл төлөх сараа сонгоно.

Өөрийн сонгосон банкаар онлайнгаар төлөлт хийнэ.



Нийгмийн даатгалын цахим дэвтэр:

НИЙГМИЙН ДААТГАЛ

- НД-ын шимтгэл
- Тэтгэвэр
- Тэтгэмж
- Нэрийн данс
- Сайн дурын даатгал
- НИЙГМИЙН ДААТГАЛЫН ДЭВТЭР**

Нийгмийн даатгалын дэвтэр

Нийгмийн даатгалын ерөнхий газар

ЗӨВЛӨЛӨК

Даатгуулагч та дараах байдалд нийгмийн даатгалын үйлчилгээ авах, нийгмийн даатгалын шимтгэл төлөхийн хяналтаа мэдээлэл авах болон өөрийн мэдээллийг шалгах боломжтой. Үүнд:

1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудас www.nidaatgal.mn
2. iOS системийн гэр утастай бол App Store, Android системийн гэр утастай бол Play store програмимаа. Нийгмийн даатгал аппликацийг татаж авах.
3. Төрийн үйлчилгээний вэб портал www.mongolia.gov.mn, E-Mongolia аппликацийн, E-baatar цахим төлбөрийн баримтын систем.
4. Төрийн үйлчилгээний цахим ГТЦД-ийнхэн болон бусад цахим систем.

САНААХ

Та өөрийн мэдээллийг цахимгаар олж, явцад нийгмийн даатгалын шимтгэл төлөлт бүртгэгдэж, цахимын болон нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээлэл дүүргүүлж, шимтгэл төлөгсөнийг үндсэн мэдээлэл алдаатай бол Нийгмийн даатгалын байгууллагад гэрээний цахим даатгуулагчийн боломжтой.

Утас: 77771289, 11-328830, цахим хуудасны хаяг: www.nidaatgal.mn/v1/onlinebat

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ДЭВТЭР

Угсийн өсөг:

Элч / элч-ийн өсөг

Нэр:


БОРИГОН

БАТ

ДААТГАЛ

Дэвтэр олгогч Нийгмийн даатгалын цахим: Хая-Уул дүүрэг

Огноо: 2021 оны 2 сар 10 өдөр



41

"Нийгмийн даатгал" гар утасны аппликейшн



"Нийгмийн даатгал" аппликейшнийг баталгаажуулахад илүү хялбар боллоо

- Та аппликейшнаа гар утсандаа татаж суулгаарай
- Бүртгүүлэх хэсэгт өөрийн мэдээллээ оруулаарай
- Бүртгүүлсэн имэйл хаягаар ирсэн холбоосоор нэвтэрч бүртгэл баталгаажуулах хэсэгт өөрийн ажиллаж байсан газраа сонгон, нийгмийн даатгалын шимтгэл тооцсон цалингийн дүнгээ оруулснаар нэвтрэх эрхтэй болно.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

НД дэвэр

Тэтгэвэр авагчийн мэдээлэл

Тэтгэмжийн зардлын мэдээлэл

Нэрийн дансны мэдээлэл

САД

Сайн дурын даатгал

НДШ шимтгэл төлөлтийн тодорхойлолт

НДШ шимтгэл төлөлт

ЭМД-ын шимтгэл төлөлт

Нөхөн даатгал

Тэтгэвэр авагчийн үндсэн мэдээлэл

Тэтгэвэр тогтоолгосон цалин

Тэтгэвэр олголт /сүүлийн 12 сар/

Тэтгэврийн түүх

Тэтгэвэр тогтоолтын хуудас

ТЭТГЭМЖИЙН ЗАРДЛЫН МЭДЭЭЛЭЛ

НЭРИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

САЙН ДУРЫН ДААТГАЛ

Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн 2006 оноос хойшхи бүх мэдээлэл


Тэтгэвэр авагчийн тэтгэвэр тогтоолтын мэдээлэл, цалин, тэтгэврийн түүх болон тэтгэвэр олголтын мэдээлэл

Тэтгэмжийн зардал авалтын сүүлийн 1 жилийн мэдээлэл

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны мэдээлэл, 2000 оноос хойшхи он тус бүрийн үлдэгдлийн мэдээлэл


Сайн дурын даатгалын гэрээ

АЛХАМ 1



Аппликейшн -рүү нэвтрч "Сайн дурын даатгал" цэсийг сонгон орох.

АЛХАМ 2




Гэрээний мэдээллээ үнэн зөвөөр бөглөн үргэлжлүүлэх товчийг дарна.

АЛХАМ 3




Гэрээний нөхцөлтэй сайтар танилцан зөвшөөрөх товчийг дарна.

АЛХАМ 4



Гэрээний нөхцөлийг нягтлан төлбөр төлөх хэсгийг сонгоно.

АЛХАМ 5



Төлбөр төлөх хэлбэрээ сонгон төлбөрөө хийснээр таны гэрээ баталгаажна.



Нийгмийн даатгалын цахим дэвтэр

Нийгмийн даатгалын дэвтэр цэс дээр дарахад таны цахим дэвтэр гарч ирнэ.

- Дэвтрээ PDF файл болгон хадгалах
- Хэвлэн авч ашиглах
- Цахим шуудангаар илгээх
- Шимтгэл төлөлтөө он, оноор харах боломжтой.

Даатгуулагчийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих цахим хяналт



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

өргөдөл

.....

.....

Регистрийн дугаар

Утасны дугаар



Даатгуулагч бичгээр гаргасан өргөдөлдөө регистрийн дугаар, утасны дугаараа бичин Нийгмийн даатгалын байгууллагад илгээнэ



Тус өргөдөл гомдол энэ ажилтан-аар дамжигдаад дараагийн ажилтан-д очно

Шалгуулсан ажилтан : П.Эрдэнэ

Шалгуулсан өгөө : 2018-10-29

ХҮЛЭЭН АБСАМ АЖИЛТАН

Хэлтэс : Бодлогын хэрэгжилт, судалгааны газар


Ажилтан : П.Эрдэнэ

Албан тушаал : Мэргэжилтэн

Авчлын утас : 11-328030-608

Гэр утас : 99138275

Ивэйн хаяг : erdene.p@ndaatgal.mn



Даатгуулагчийн өргөдөл дээр бичсэн утасны дугаараар шийдвэрлэгдсэн тухай мессеж очно.

www.ndaatgal.mn сайтын өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явц програмыг ашиглан шийдвэрлэлтийн явц болон хариугаа лавлах боломжтой.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСҮҮДТЭЙ ХОЛБОО БАРИХ УТАСНЫ ЖАГСААЛТ

Д/д	Хэлтсийн нэр	Утасны дугаар	И-мэйл хаяг	Фэйсбук хаяг
1	Багануур дүүрэг	7021 0021	baganuur@ndaatgal.mn	Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс
2	Багахангай дүүрэг	9696 6916	nbagahangai@yahoo.com	Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс
3	Баянгол дүүрэг	7014 3205	bayangol@ndaatgal.mn	Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс
4	Баянзүрх дүүрэг	7555 8484	bayanzurh@ndaatgal.mn	Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс
5	Налайх дүүрэг	7023 2369	nalaih@ndaatgal.mn	Налайх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс
6	Сонгинохайрхан дүүрэг	7017 3261	songinohairhan@ndaatgal.mn	Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс
7	Сүхбаатар дүүрэг	7000 4300	sbdndaatgal@gmail.com	Сүхбаатар Дүүрэг Нийгмийн Даатгалын Хэлтэс
8	Хан-Уул дүүрэг	7510 3030	Han-uul@ndaatgal.mn	Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс
9	Чингэлтэй дүүрэг	7000 7790	chingeltei@ndaatgal.mn	Чингэлтэй Дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс
10	Архангай аймаг	7033 2659	arhangai@ndaatgal.mn	Архангай аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс
11	Баян-Өлгий аймаг	7042 2101	bayanulgii@ndaatgal.mn	Баян-Өлгий Нийгмийн даатгалын хэлтэс
12	Баянхонгор аймаг	7044 4475	bayanhongor@ndaatgal.mn	Баянхонгор Нийгмийн Даатгалын хэлтэс
13	Булган аймаг	7034 2226	bulganndaatgal@gmail.com	Булган Нийгмийн Даатгалын Хэлтэс
14	Говь-Алтай аймаг	7048 3634	govialtai@ndaatgal.mn	Говь-Алтай Нийгмийн Даатгалын хэлтэс
15	Говьсүмбэр аймаг	7054 1289	Ndaatgal_gsa@yahoo.com	Говьсүмбэр аймгийн нийгмийн даатгалын хэлтэс
16	Дархан-Уул аймаг	7505 7799	darhan@ndaatgal.mn	Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс
17	Дорнод аймаг	7058 5955	dornod@ndaatgal.mn	Дорнод аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс
18	Дорноговь аймаг	7052 3223	Dornogovi.ndh@gmail.com	Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс
19	Дундговь аймаг	7059 2207	Dug_ndaatgal@gov.mn	Дундговь НДХэлтэс
20	Завхан аймаг	9546 2481	zavkhan@ndaatgal.mn	Завхан аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс
21	Орхон аймаг	7577 6699	orhon@ndaatgal.mn	Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс
22	Өвөрхангай аймаг	7032 2136	uvurhangai@ndaatgal.mn	Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс
23	Өмнөговь аймаг	7053 3356	umnugovi@ndaatgal.mn	Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс
24	Сүхбаатар аймаг	7051 8915	suhbaatar@ndaatgal.mn	Сүхбаатар Аймаг Нийгмийн Даатгал
25	Сэлэнгэ аймаг	7036 3087	Selenge.ndaatgal@gmail.com	Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс
26	Төв аймаг	7027 2315	admin@ndaatgal.to.gov.mn	Нийгмийн даатгалын Төв аймаг
27	Увс аймаг	7045 4805	Uvs@ndaatgal.mn	Увс Аймаг Нийгмийн Даатгалын хэлтэс
28	Ховд аймаг	7043 3046	hovd@ndaatgal.mn	Ховд аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс
29	Хэнтий аймаг	9333 0553	Hen.ndaatgal0001@gmail.com	Хэнтий Нийгмийн Даатгалын Хэлтэс
30	Хөвсгөл аймаг	7509 1000	niigmiindaatgal@khs.gov.mn	Хөвсгөл Аймгийн Нийгмийн Даатгалын Хэлтэс

АЛБАН ЖУРМЫН БОЛОН, САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨХ ДАНСНЫ ДУГААР

Архангай аймаг

Төрийн банк	180000019632
Хаан банк	5135055961

Баян-Өлгий аймаг

Төрийн банк	291400007046
Хаан банк	5180028126
Капитрон банк	3005005300

Баянхонгор аймаг

Төрийн банк	230000030094
Хаан банк	5246025611
Голомт банк	6100000749
Хас банк	5001360217

Булган аймаг

Төрийн банк	120000032694
Хаан банк	5270260598

Говь-Алтай аймаг

Төрийн банк	240000028398
Хаан банк	5315059962
Хас банк	5000144613

Говь-Сүмбэр аймаг

Төрийн банк	300000020314
Хаан банк	5990039294

Дархан-Уул аймаг

Төрийн банк	140800001459
Хаан банк	5045001096
Капитрон банк	3006013806
Чингис хаан банк	3961411008
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	2905001009
Худалдаа хөгжлийн банк	403011889

Дорноговь аймаг

Хаан банк	5360345438
Капитрон банк	3021000807
Хас банк	5000016940
Голомт банк	5401009061
Худалдаа хөгжлийн банк	408015471

Дорнод аймаг

Төрийн банк	260000029720
Хаан банк	540517789
Хас банк	5000158740
Голомт банк	4701003062
Худалдаа хөгжлийн банк	401065891

Дундговь аймаг

Төрийн банк	220000038204
Хаан банк	5450099464

Завхан аймаг

Төрийн банк	170000026256
Хаан банк	5495008996

Орхон аймаг

Төрийн банк	240501939408
Хаан банк	5090092658
Голомт банк	4001028735
Капитрон банк	3007004173
Худалдаа хөгжлийн банк	4070250509

Өвөрхангай аймаг

Төрийн банк	190000343863
Хаан банк	5540021665

Өмнөговь аймаг

Төрийн банк	210000020189
Хаан банк	5585080619
Хас банк	5000537488
Голомт банк	5205009577
Капитрон банк	3017003108
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	2902002527
Худалдаа хөгжлийн банк	414005235
Чингис хаан банк	2201000041

Сүхбаатар аймаг

Хаан банк	5630082185
Хас банк	5000166224
Голомт банк	5900000513

Сэлэнгэ аймаг

Төрийн банк	151700031311
Хаан банк	5675357548
Голомт банк	4325105272
Хас банк	5001141639
Чингис хаан банк	2101000009

Төв аймаг

Төрийн банк	310000059814
Хаан банк	5721100330

Увс аймаг

Төрийн банк	162000002748
Хаан банк	5800202604
Хас банк	5000173979
Голомт банк	62000000567

Ховд аймаг

Төрийн банк	110000035625
Хаан банк	5845138908
Голомт банк	5601001035
Хас банк	5000170559

Хөвсгөл аймаг

Төрийн банк	200000173460
Хаан банк	5890136712
Голомт банк	4901000803

Хэнтий аймаг

Төрийн банк	250000041253
Хаан банк	5935002012
Хас банк	5000031699

АЛБАН ЖУРМЫН БОЛОН, САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨХ ДАНСНЫ ДУГААР

Багануур дүүрэг

Төрийн банк	330700001638
Хаан банк	5750180162
Голомт банк	4601029891
Хас банк	5000333425

Багахангай дүүрэг

Төрийн банк	300500011527
Хаан банк	5754001624

Баянгол дүүрэг

Төрийн банк	105100004490
Хаан банк	5034189999
Голомт банк	1805002406
Улаанбаатар хотын банк	2602003516
Худалдаа хөгжлийн банк	499071483

Баянзүрх дүүрэг

Төрийн банк	105300001232
Хаан банк	5064063696
Улаанбаатар хотын банк	2600072390
Голомт банк	1235100652
Капитрон банк	3022020001
Худалдаа хөгжлийн банк	499071405

Налайх дүүрэг

Төрийн банк	312500527474
Хаан банк	5749024593
Хас банк	5000192425

Сонгинохайрхан дүүрэг

Төрийн банк	103700002249
Хаан банк	5019261648
Голомт банк	2900000455
Улаанбаатар хотын банк	2601032649
Худалдаа хөгжлийн банк	468015369
Хас банк	5002062240
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	2909004386

Сүхбаатар дүүрэг


Төрийн банк	103400014871
Хаан банк	5009126484
Голомт банк	1410008726
Капитрон банк	3020004567
Улаанбаатар хотын банк	2600004872
Чингис хаан банк	5101000040
Худалдаа хөгжлийн банк	499135040

Хан-Уул дүүрэг

Төрийн банк	105400014166
Хаан банк	5022395214
Улаанбаатар хотын банк	2603002465
Голомт банк	2105019063
Капитрон банк	3008002681
Худалдаа хөгжлийн банк	406005146

Чингэлтэй дүүрэг

Төрийн банк	102100001565
Хаан банк	5003440919
Голомт банк	8125100252
Худалдаа хөгжлийн банк	429001668



*Энэхүү гарын авлагыг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын
“Эдийн засгийг төрөлжүүлж, хүртээмжтэй өсөлтийг хангах хүрээнд
албан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл (MNG/18/01/RBS)”-ийн
дэмжлэгтэйгээр хэвлэв.*

Номын формат: 70x100 1/16, (B5)

Үсгийн гарнитур: Mogul Freeset

Хэвлэлийн хуудас: 4 х.х